



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Статистикийн хэлтсийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2024 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 135

танай _____ ны № _____ т

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.МӨНХБАТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Статистикийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Статистикийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд өрхийн нийгэм, эдийн засаг, ажиллах хүчний, цаг ашиглалтын судалгааг хийж, МУ-ын нэгдсэн судалгаанд нэгтгүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвийн санхүүжилтээс бэлтгэсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэлд тусгаж, шилжүүлэх, данснаас хасах шийдвэрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 17 дугаар хуралдааны тогтоолыг баримтлан ажиллаж байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

006020323

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, ҮСХ-ны даргаар 97.5 хувьтай үнэлүүлэн "маш сайн" үнэлгээ авсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2022.12.31.	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,794.0	1,684.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	125,930.7	106,433.8
	Нийт хөрөнгийн дүн	127,724.7	108,117.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	127,724.7	108,117.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	127,724.7	108,117.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	426,829.3	347,095.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	340,427.6	366,702.0
	Үйл ажиллагааны үр дүн	86,401.7	(19,606.9)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	86,401.7	(19,606.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,322.9	127,724.7
	Тайлант оны үр дүн	86,401.7	(19,606.9)
	Эцсийн үлдэгдэл	127,724.7	108,117.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	346,931.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	346,931.4
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	180,001.5
	Урсгал зардал	-	180,001.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	180,001.5
	Улсын төсвөөс санхүүжих	-	180,001.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 786.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 786.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлаар бүртгэсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 786.9 мянган төгрөгийг залруулав.

Аудитаар нийт 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,382.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын төсвийн санхүүжилтээс бэлтгэсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэлд тусган, шилжүүлэх, данснаас хасах шийдвэрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 17 дугаар хуралдааны тогтоолыг баримтлан ажиллаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "*Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*" гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч эзэмшлийн гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулан, хөрөнгийн асуудлыг хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаар шийдвэрлүүлж хэвших.

2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгийн дээш орлогын мөнгөн гүйлгээг 5,481.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 11,407.8 мянган төгрөгийн 3 гүйлгээг илүү мэдээлж, зөрүүтэй тайлагнасан. төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6,454.4 мянган төгрөгийн 4 шийдвэрийг 12

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

дугаар сард нөхөж мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ийн 6.3-т "Шилэн дансны тухай хуулийн 7.1-д заасан дараах албан тушаалтан шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу оруулах үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн оруулж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлаар бүртгэсэн					1	786.9						
Дүн					1	786.9						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын төсвийн санхүүжилтээс бэлтгэсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэлд тусган, шилжүүлэх, данснаас хасах шийдвэрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 17 дугаар хуралдааны тогтоолыг баримтлан ажиллаж байгаа	1	-					1	-				
Дүн	1	-		-	-	-	1	-				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түвшэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	Статистикийн хэлтэс	1	1			1				
	ТШЗ-ийн дүн	1	1			1				
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
	НИЙТ	1	1			1				